



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/103

Зуунмод сум

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 03 дугаар тушаалаар эрх шилжин улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжих Сумын ЗДТГ-ын барилгын засвар (Төв, Жаргалант сум)-ын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

С.Магнайбаяр (Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Гомбодорж (Жаргалант сумын Засаг даргын орлогч)
А.Хажидмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
М.Оюунсүрэн (Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Ундармаа (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (С.Магнайбаяр)-д, ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



4122010338